

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2023. оны 12. сарын 13. өдөр

№ R-2023-84

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг  
ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТ ХЭЛБЭРЭЭР ЯВУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хороо (“СЗХ”)-ны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын 2.2 дахь хэсэг, ХасБанк ХК (“Банк”)-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“ТУЗ”)-ийн 2023 оны 12 дугаар сарын 11-13-ны өдрийн хооронд хийсэн цахим санал хураалтаар гарсан шийдвэрийг үндэслэн:

**ТЭМДЭГЛЭХ НЬ:**

- ТУЗ нь 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн R-2023-72 дугаар тогтоолоороо хагас жилийн ногдол ашиг зарлан хуваарилахыг хувьцаа эзэмшигчдэд зөвлөмж болгосныг;
- Банкны Дүрмийн 8.6 (ii)-д зааснаар ногдол ашиг хуваарилах шийдвэр нь стратегийн асуудал тул хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэхийг; мөн
- Хагас жилийн ногдол ашиг зарлан хуваарилах асуудлыг эцэслэн батлах болон холбогдох бусад шийдвэрийг гаргуулах зорилгоор Банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТ ХЭЛБЭРЭЭР ЯВУУЛАХ НЬ ЗҮЙТЭЙ ГЭЖ БАНКНЫ ТУЗ ҮЗСЭН БОЛОХЫГ ТУС ТУС ТЭМДЭГЛЭВ.

**ТОГТООХ НЬ:**

- Банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТЫН ХЭЛБЭРЭЭР ЯВУУЛСУГАЙ.
- ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГААР БАНКНЫ ЕРӨНХИЙ АУДИТОР Э.ҮНДАРМААГ ТОМИЛСУГАЙ. ТУС КОМИССЫН ГИШҮҮДИЙГ ХОЛБОГДОХ ДОТООД ЖУРМЫН ДАГУУ ТОМИЛОХЫГ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.ЦЭВЭГЖАВД ҮҮРЭГ БОЛГОСУГАЙ.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТ ХЭЛБЭРЭЭР ЯВУУЛАХ ТУХАЙ МЭДЭГДЛИЙГ 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДРИЙН ДОТОР СЗХ БОЛОН МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ (“МХБ”)-Д ХҮРГҮҮЛЭХИЙГ ТУЗ-ИЙН АЖЛЫН АЛБАНД ДААЛГАСУГАЙ.
- ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТ ЯВУУЛАХ ТУХАЙ ЗАР МЭДЭЭГ МХБ-ИЙН ЦАХИМ ХУУДАС, ӨДӨР ТУТМЫН СОНИН, БАНКНЫ АЛБАН ЁСНЫ ВЕБ САЙТ ([www.xacbank.mn](http://www.xacbank.mn)), Сошиал Орчин дахь албан ёсны хаягаар болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, зарын давталтыг тийнхүү нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх зарласан хэлбэрээр дахин нэг удаа нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

5. Эчнээ санал хураалтад оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр байхаар тогтоосугай.
6. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлын жагсаалт, гаргах шийдвэрийн төсөл, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилериин компаниудад хүргүүлэхийг Зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
7. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлыг 1 дүгээр хавсралтаар, Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудалтай холбоотой баримт бичгийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар, Тооллогын комиссын бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралтаар, Эчнээ санал хураалтын саналын хуудсыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчид шийдвэрлэх асуудалтай холбоотой баримт бичигтэй өөрийн үйлчлүүлдэг брокер, дилериин компанийн байранд ажлын цагаар танилцах боломжийг энэхүү тогтоолын 9-д заасан хугацаанд хангаж ажиллахыг Зохион байгуулах комисст даалгасугай.
9. Хувьцаа эзэмшигчдэд саналыг 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 16:00 цаг хуртэл хугацаанд цаасаар брокер дилериин компаниар дамжуулан, эсхүл Банкны нийт салбар, тооцооны төвөөр дамжуулан авах боломжийг бүрдүүлэн ажиллахыг хурал Зохион байгуулах комисст даалгасугай.
10. Эчнээ санал хураалтаас гаргасан шийдвэр, бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд МХБ, СЗХ-д хүргүүлэхийг ТУЗ-ийн Ажлын албандаа даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХАСБАНК

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТУЗ-ИЙН НАРИИН БИЧГИЙН ДАРГА

САНЖАЙ ГУПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ